



MNR
MONGOLIAN NATIONAL
REPORTING AUDIT

Г “ИХ ИРЭЭДҮЙ КАПИТАЛ ББСБ” ХХК-ийн
хувьцаа эзэмшигчдэд

**МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ТАЙЛАГНАЛ
АУДИТ ХХК**

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
5-р хороо, Самбуугийн гудамж, М Плаза
оффис 6 давхар, 607 тоот
Утас: 99117121; 89601000
И-мэйл: info@mnraudit.mn

2024.01.23 дугаар 24-01/2

Танай _____ - ны дугаар _____ -т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид “ИХ ИРЭЭДҮЙ КАПИТАЛ ББСБ” ХХК (‘Компани’ гэх)-ийн 2023 оны 12 сарын 31-рх Санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Компанийн 2023 оны 12 сарын 31-ны өдрөөр санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-уудын дагуу үнэн зөв толилуулж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)- өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний гаргасан тайланд томоохон хэмжээний аудитын гол асуудал байхгүй гэж тодорхойлж байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-уудын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр аргагүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах Компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага (Үргэлжлэл)

асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ. Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу бид аудитын хэсэг болгон мэргэжлийн үнэлэмж ашиглаж, аудитын турш мэргэжлийн үл итгэх байр суурийг баримталдаг. Түүнчлэн бид:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилан үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг үл ойшоох явдлууд багтсан байж болно.
- Нягтланд бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ болон хугацаа, аудитын томоохон илрүүлэлт, аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын томоохон дутагдал болон холбогдох бусад асуудлаар засаглах удирдлагатай харилцдаг.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль” -ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох “ИХ ИРЭЭДҮЙ КАПИТАЛ ББСБ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Монголын Үндэсний Тайлагнал Аудит ХХК Ч.БАТТӨМӨР

Улаанбаатар хот, Монгол Улс

2024 оны 01 дугаар сарын 23



Мэргэшсэн нягтлан бодогч, Партнер

“ИХ ИРЭЭДҮЙ КАПИТАЛ ББСБ” ХХК

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

		/төгрөгөөр/	
Тодруулга		2022	2023
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгөн хөрөнгө	5	700,751,378.92	1,213,009,918.80
Зээл /цэвэр/	6	6,362,272,762.22	9,483,586,385.52
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	7	143,467,490.60	188,450,576.10
Бусад авлага		13,671,109.50	15,917,769.10
Бусад хөрөнгө		28,604,610.60	31,612,954.63
Эргэлтийн хөрөнгийн дүн		7,248,767,351.84	10,932,577,604.15
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө (цэвэр)	8	244,276,441.45	241,512,324.48
Биет бус хөрөнгө (цэвэр)		30,757,808.21	7,594,520.54
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		275,034,249.66	249,106,845.02
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		7,523,801,601.50	11,181,684,449.17
ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл		-	-
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	9	2,408,758,039.00	2,038,758,039.00
Хуримтлуулж тооцсон хүүний өглөг	10	131,431,174.94	126,666,806.28
Бусад өглөг	11	19,830,810.83	26,963,551.92
Богино хугацаат өр төлбөрийн дүн		2,560,020,024.77	2,192,388,397.20
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл		-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн		-	-
Нийт өр төлбөрийн дүн		2,560,020,024.77	2,192,388,397.20
Өөрийн хөрөнгө			
Энгийн хувьцаа	12	3,000,000,000.00	6,500,000,000.00
Хуримтлагдсан ашиг		1,963,781,576.73	2,489,296,051.97
Нийт өөрийн хөрөнгийн дүн		4,963,781,576.73	8,989,296,051.97
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		7,523,801,601.50	11,181,684,449.17

“ИХ ИРЭЭДҮЙ КАПИТАЛ ББСБ” ХХК

АШИГ АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

		/төгрөгөөр/	
	Тодруулга	2022	2023
Хүүгийн орлого	14	2,026,105,442.49	2,453,328,515.98
Хүүгийн зардал		-	-
ЦЭВЭР ХҮҮГИЙН ОРЛОГО		2,026,105,442.49	2,453,328,515.98
Хүүгийн бус орлого	15	49,513,706.47	56,033,988.01
Хүүгийн бус зардал		(1,017,432,973.04)	(1,316,477,852.79)
Ханшийн зөрүүний алдагдал		(832,819.86)	(2,385,398.31)
Ерөнхий удирдлагын зардал	16	(817,446,137.82)	(1,153,448,983.86)
Эрсдлийн сангийн зардал	17	(199,154,015.36)	(160,643,470.62)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ		1,058,186,175.92	1,192,884,651.20
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	18	3,055,192.69	166,120.25
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	19	(21,847,685.55)	(43,124,070.47)
ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ)		1,039,393,683.06	1,149,926,700.98
Орлогын татварын зардал	11.1	(110,292,440.43)	(124,412,225.74)
ТАЙЛАНТ ЖИЛИЙН ТАТВАРЫН ДАРААХ АШИГ		929,101,242.63	1,025,514,475.24